



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/133

Биндэр сум

**Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх,
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2026 оны А/50 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2026 оны А/391 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд сумын нутаг дэвсгэрт байгаа бүх хургыг хамруулан 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д даалгасугай.

2.Дархлаажуулалтыг хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирлуудад, шаардагдах вакциныг татан авч хуваарилах, заавар, арга зүйгээр хангаж ажиллахыг тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-т, ажлын явц, вакцины зориулалт гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д үүрэг болгосугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, өөрийн багийн нутаг дэвсгэрт байгаа малчдад зар хүргэж бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

